

Ядуурал юунаас болж байна вэ?

Ю. Туул.

Улсын Статистикийн газрын мэрэгжилтэн

Нийгэм, эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжих шилжилтийн үед гарч буй төр, нийгэм, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь ард түмний амьдралд шууд нөлөөлж, хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал, өвчлөл, гэмт хэрэг эрс нэмэгдэж нийгмийн хямралыг бий болгосон.

Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Статистикийн Газар нь Дэлхийн Банктай хамтран 1995 онд "Монголын ард түмний Амьжиргааны түвшин"-гийн түүвэр судалгааг манай орны эдийн засаг, байгаль газар зүйн бүс нутгийг эдийн засгийн хөгжлийн түвшин, хүн амын суурьшил, амьдралын онцлог нөхцлийг төлөөлөх боломж бүхий 1500 өрх дээр явууллаа. Энэхүү судалгаа нь Олон улсын байгууллагаас Монголын Засгийн Газартай хамтран Монгол дахь ядуурлын байдалд хийж буй анхны үнэлгээ юм.

Хүний наад захын зохистой хэрэглээнээс доогуур хэмжээний хэрэглээтэй хүнийг ядуу гэнэ. Энэ тодорхойлолтыг үндэслэн ядуу хүн, өрхийг бусдаас ялган зааглаж байгаа хязгаарыг олон улсын хэмжээнд **ядуурлын шугам** гэж томьёолдог бол манайд амьжиргааны баталгаажих доод түвшин гэдэг.

Амьжиргааны баталгаажих доод түвшинг тогтоохдоо хүний эрүүл мэнд, физиологийн наад захын зохих шаардлагыг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээг хамгийн энгийн бөгөөд хямд төсрөөр хангахаар тооцож үнийн дүнгээр тодорхойлж ирсэн билээ. Монголын Засгийн газраас хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинг 1991-1995 онд нийтдээ 8 удаа шинэчлэн тогтоосон. 1995 онд амьжиргааны баталгаажих доод түвшин хотод өрхийн нэг хүнд сард 8000 төгрөг, хөдөөд 6900 төгрөгөөр тогтоосон. 1997 онд бүс нутгаар анх удаа тогтоов.

Нийгмийн хямралын нэг илрэл болсон ядуурал, түүний хамарч байгаа хүрээ, ядуурлын түвшин, ядууралд хүргэж байгаа үндсэн шалтгаан, ядуурлаас үүсэн гарч буй үр дагавар, ядуурлыг бууруулах арга замыг судлахдаа Монголын Засгийн газраас эмэгтэйчүүд тэргүүлсэн өрх, хүүхэд, өндөр настан, тэтгэврийн хүмүүсийг нийгмийн шилжилтийн бэрхшээлд хамгийн их өртөж буй эмзэг хэсэг гэж тодорхойлсоныг голлон анхаарав.

Энэ удаагийн (1995 оны 6 сард) судалгаанаас үзэхэд Монголын ард түмний амьжиргааны доод түвшин буюу ядуурлын шугам нь 7471 төгрөг болж, нийт хүн амын 36 хувь буюу 828 мянган хүн ядуу байдалд амьдарч байна. Судалгаагаар тогтоогдсон ядуурлын шугам нь манай засгийн газраас тухайн үед батлан гаргасан амьжиргааны баталгаажих доод түвшинд ойр байна.

Манай оронд ядуурал хот, аймгийн төв, суурин газарт хөдөө нутгаас илүү төвлөрч байхад олонхи хөгжиж байгаа оронд ядуурал нь хөдөө орон нутагтаа төвлөрч ядуусын тоо хэмжээ хот, суурингаасаа нэлээд их байдаг байна. Энэ нь манай орны бас нэг онцлог шинж, төрх болж харагдав.

Ядуурлын хүрээ, хэмжээ

	хүн ам (мян)	Хувийн жин %	
		нийт өрхөд	ядуу өрхийн
Хөдөөд	350	33.1	42.3
Аймгийн төвд	471	48.0	56.9
Улаанбаатар хот	214	35.1	25.8
Улсын түвшинд	828	36.3	100

Хот, суурин газрын өрхийн 35 - 48 орчим хувь, хөдөө нутгийн 30 гаруй хувь ядуус байна.

Энэ нь шилжилтийн үед нийгэм эдийн засагт гарч буй өргөн хүрээтэй гүнзгий өөрчлөлтийг даган төв, суурин газарт улсын үйлдвэр, үйлчилгээний газар олноор хаагдахын зэрэгцээ бүтцийн өөрчлөлт гарсан, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ буурч, тогтворжин бүрдэж буй зах зээлээ даган хөдөө орон нутгаас хот, аймгийн төв рүү хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг бодит байдал нөлөөлсөн байна.

Манай орны хүн амын 70 гаруй хувь нь суурьшдаг аймаг, орон нутагт нийт ядуу өрхийн дөрөвний гурав нь байгаагаас үзэхэд энд 3 өрх тутамын нэг нь, аймгийн төвийн бараг 2 өрх тутмын нэг нь ядуу байна. Гэхдээ ядуурлын хүрээ өргөжиж байгаа дүр төрх харагдахад хүргэж байгаа нэг шалтгаан нь үнийн хиймэл өсөлт байгааг анхаарах нь зүйтэй.

Хот, хөдөөгийн амьжиргааны түвшингийн хэмжээ нь хэрэглээний сагсны бүтцийн ялгаанаас гадна үнийн ялгаанаас хамаарч зөрүүтэй байгаа нь дараахи хүснэгтээс харагдаж байна.

Амьжиргааны доод түвшингийн хэрэглээнд үнийн нөлөөлөл (хүнд ногдох сарын хэрэглээ)

	Доод хэмжээний хэрэглээ (төг)			Үнийн индекс %
	Бүгд	үүнээс: хүнсний	хүнс. хэрэг. хувийн жин, %	
Хээрийн бүс : төвд	6416	4907	76.5	0.89
хөдөөд	5146	3904	75.9	0.71
Талын бүс : төвд	6549	4731	72.2	0.9
хөдөөд	5730	4105	71.6	0.79
Говийн бүс : төвд	6811	4854	71.3	0.94
Алтайн бүс : төвд	8323	5799	69.7	1.15
хөдөөд	6842	4854	70.9	0.95
Улаанбаатар хот	8053	5564	69.1	1.11
Улсын түвшинд	7250	5084	70.1	1

Хэрвээ улсын хэмжээнд үнийн индексийг 1 -тэй тэнцүү гэж үзвэл алс холын Алтайн бүс болон Улаанбаатар хотод хүнсний болон хүнсний бус бараа, үйлчилгээний үнэ, тариф 0.11-0.15 хувиар өндөр байна. Гэхдээ энэ судалгааг явуулах үед зарим бараа, үйлчилгээ зах зээлд бүрэн шилжээгүй байсаныг сануулах нь зүйтэй юм. Хот, аймгийн төв дэх улсын орон сууцанд амьдардаг хүмүүсийн хувьд сууц, халаалт, түлш, цэвэр, бохир ус болон бусад зарим үйлчилгээний үнэ, тариф чөлөөлөгдөөгүй байсанаас хамаарч хотын хэрэглэгчийг бодвол хөдөөгийн хүмүүсийн хэрэглээ нь (тэдний түлш, усны хэрэглээ үндсэндээ үнэгүй байгааг эс тооцвол) зах зээлд үндсэндээ харьцангуй бүрэн хамрагдсан гэж үзэж болох талтай.

Энд өгүүлж байгаа тоон үзүүлэлт нь нэг удаагийн түүвэр судалгааны дүн учир бид сонирхож байгаа үзэгдлийнхээ ерөнхий дүр зургийг эндээс томъёолох нь л гол асуудал. Хэдийгээр ядуурлын хүрээ хурдан тэлж байгаа, ядууралд хүргэж буй олон бодит нөхцөл байгаа ч нөгөө талаасаа ядуурлыг тодорхойлж байгаа бидний аргачлал, бүртгэл мэдээлэл, мөн манай тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгож буй тогтолцооны цоорхойг сөрөгөөр ашиглах, хувийн сонирхол давамгайлж ядуу хүн, өрхийн тоог зохиомлоор өсгөж байгаа нөлөөлөл ч байгааг хэлэх нь зүйтэй.

Түүнчлэн аль ч бүс нутгийн хувьд ядуурлын хамрах хүрээ нь янз бүр байгаа ч ядуурлын түвшин гүн байгаа нь ядуу хүний хэрэглээний зардлын 70 орчим хувийг зөвхөн хүнсний хэрэглээ эзлэж байгаагаас тодорхой байна.

Ядуурлын түвшин, %

	Ядуу өрх	Нэн ядуу	Ноцтой ядуу
Хөдөөд	33.1	8.9	3.6
Аймгийн төвд	48	12.2	5.7
Улаанбаатар хот	35.1	10.4	4.5
Улсын түвшинд	36.3	10.9	4.8

Өрхийн гишүүдийн хэрэглэх удаан эдэлгээтэй бараа болон орон сууц худалдан авах чадвар, өрхийн үл хөдлөх хөрөнгөнд гарч буй өөрчлөлт мөн өрхийн өр зээлийн асуудалд гарч байгаа өөрчлөлтийг энэ удаа хүн амын амьжиргааны түвшин, хэрэглээг тодорхойлоход хамруулаагүй болно. Мөн татваруудыг ч оруулаагүй. Ядуу өрхийн хувьд өрхийн гишүүд нь ямарч нас, хүйс, боловсролтой гишүүд байж болох бөгөөд өрхийн хүнсний хэрэглээг тодорхойлохдоо зарим шилжүүлэх коэффициентүүдийг ашиглан өрхийн гишүүн бүрийн хэрэглээг жишсэн дундаж хүнд шилжүүлж тодорхойлж байна. Удаан эдэлгээтэй бараа, үл хөдлөх хөрөнгийн хэрэглээг хамруулахгүйгээр судалгаанд хамрагдсан өрхийн хэрэглээг судлахад дээд зэргийн хэрэглээтэй өрхийн 20 хувийн хэрэглээний хэмжээ нь хамгийн ядуу өрхүүдийн 20 хувийнхны хэрэглээнээс 5 дахин өндөр байгаа нь

манайд ядуу баяны зааг, ялгаа нэлээд гүн байгааг илэрхийлж байгаа нэг үзүүлэлт юм.

Өрхийн гишүүдийн хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдлыг судлах нь ядуурлыг тодорхойлох нэг гол зүйл юм. Гэхдээ энэ нөлөөлөл тус бүрийг дэлгэрэнгүй судлаж дараа дараагийн нийтлэлд тусгах болно. Манай нийт өрхийн тавны нэг буюу таван өрх тутамын нэг нь эмэгтэй тэргүүнтэй өрх байна. Ядуу өрхийн хувьд эмэгтэй тэргүүнтэй өрхийн 60 хувь нь ядуу байхад эрэгтэй тэргүүнтэй өрхийн 30 орчим хувь нь ядуу байгаа нь өрхийн гишүүдийн боловсролын түвшин, ажил эрхлэлт, амьдралыг авч явах ухаанаас хамаарч байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд байгаа ажил эрхэлж байгаа хүн мөн хувийн малын тоо эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийнхөөс /энд эмэгтэй тэргүүлэгчтэй өрх дээр тусгай судалгаа явуулах шаардлагатай) цөөхөн байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хүн амын тоог өсгөх үүднээс төрөлтийг дэмжиж, сургуулийн өмнөх насны хүүхдийг төлбөргүй асрах, сургах байгууллага олноор ажиллаж, ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах, шаардлагатай хүүхдийг дотуур байраар, хөдөлмөрийн насны эрүүл иргэн бүрийг хөдөлмөрлөх, бүх иргэдийг эмнэлгийн үйлчилгээнд төлбөргүй хамруулах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг хүндээ харьцангуй ойр байлгах г.м нэг талын сайхан нөхцөл, нөгөө талаар ийм асрамжийн тогтоолцоо нь задран унасан нь манай ард түмний амьдралд эрс өөрчлөлтийг гаргав. Хэдийгээр тухайн үедээ өрх, хүн бүрийн хувьд орлогын түвшин нь ялгаатай ч нийтлэг шинж нь - өрхийн орлогын үндэс зөвхөн цалин, хөлс байсан явдал юм.

Өрхийн орлогын бүтэц %

	хот			хөдөө		
	1989	1990	1995	1989	1990	1995
Мөнгөн орлого	100	100	100	100	100.0	100
- Цалин	84.6	84.5	51.1	76.1	75.8	26.5
- Тэтгэвэр, тэтгэмж	8.9	9.3	7.2	6.2	7.0	6.0
- Мал, ХАА-н бүтээгдэхүүн борлуулсаны	1.7	2.0	2.5	1.4	13.1	41.3
- Хувиараа үйлдвэрлэсэн ХАА-н бус бүтээгдэхүүн борлуулсаны			1.2	83.7		3.3
- Хувийн үйлчилгээний			4.9			2.8
- Арилжаа наймааны			14.1			9.6
- Түрээсийн			0.1			0.1
- Тусламж, нөхвөр			1.3			0.6
- Зээл			8.4			6.6
- бусад	4.8	4.2	9.2	6.3	4.1	3.3

Одоо хөдөөгийн ядуу өрх дээд тал нь 15 толгой малтай байгаа ба малын ашиг шим бага, зах зээл, тэтгэлэг, дэмжлэг, зайлшгүй үйлчилгээнээс алслагдмал байна. Хэдийгээр ядууралын хамрах хүрээ нь хөдөөд бага байгаа боловч дэд бүтцийн хөгжил сул, байгалийн гэнэтийн гамшигт өртөмтгий байдал, санхүү, мөнгөний гачаал нь цөөн тооны малтай өрхийг тун эмзэг байдалд хүргэж болох тохиолдол маш ойрхон байгааг **дохио** болгож байна.

Ядууралд хүргэж буй үндсэн шалтгаанууд:

Ядууралд хүрэхэд нөлөөлж байгаа гадаад болон дотоод дээр дурьдсан хэд хэдэн нөлөөллөөс гадна дараахи бодит шалтгаануудыг дурьдаж болно.

1. Ажилгүйдэл: Судалгаагаар ажилгүйчүүдийн 60 хувь нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур амьдарч байна. Ажилгүйдлийн хэмжээ өдөр ирэх тутам нэмэгдсээр байгаа нь ядууралд хүргэж байгаа гол шалтгаан болж байна. Хот, суурин газрын боломжийн амьдралтай өрхийн ажилгүйчүүдийн дөнгөж 7 хувь нь ядуу байхад, хотын нэн ядуусын тал хувь нь ажилгүйчүүд байна. Харин хөдөөгийн ядуусын гуравны нэг нь ажилгүй байна. Гэхдээ дээрхи өрхүүд нь ам бүл олонтой, ихэнхдээ хөдөлмөрийн насны залуучууд байгаа ба залуу гэр бүлүүд ч хамрагдаж байна.

Эндээс үзэхэд ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулах нэг үндсэн чиглэл болох юм.

2. Боловсрол, мэрэгжил: Ажилгүйчүүдийн дийлэнхи нь тодорхой мэрэгжил, боловсролтой хэдий ч энэ нь зах зээлийн хэрэгцээ, эрэлттэй нийцэхгүй байгаа нь ажилгүйдлийн бас нэг шалтгаан болж байна. Иймээс тасралтгүй сургалтыг зохион байгуулах нь дараагийн нэг бодит арга зам болох юм. Боловсрол, мэрэгжил, сургалтын тухай ойлголт нь зах зээлийн энэ үед улам өргөн хүрээтэй болж байна.

3. Хөдөлмөрийн хөлсний хэмжээ: Хөдөлмөрийн хөлсний өнөөгийн мөрдөж байгаа систем боловсронгуй бусаас хамаарч ажил эрхэлж байгаа ч амьжиргаа доогуур байгаа өрх нийтлэг байна. Судалгаанаас үзэхэд ядуурлын шугам буюу амьжиргааны баталгаажих доод түвшинг ялигүй өөрчлөхөд ядуурлын талаар хийх тооцоо, үнэлэлтүүдэд ихээхэн нөлөө өөрчлөлтүүд гарах нь илэрхий байна. Түүнчлэн ядуурлын гүнзгийрэлт өндөр байгаа одоогийн нөхцөлд ядуу өрхийн гишүүд (бүгд зэрэг ажилтай болох боломжгүй) хэдийгээр ажлын байртай болж, ажил эрхэлсэн ч ядуурлаас хурдан гарах боломжгүй, нөгөө талаас ажил эрхэлж байгаа өнөөдөр энэ ядуурлын шугаманд маш ойр байгаа өрхүүд ч хөдөлмөрийн хөлсний хэмжээ, үнийн өсөлт болон түүнтэй уялдах бусад олон нөлөөллөөс хамаарч ядуучуудын эгнээнд маргааш ороход ч бэлэн байна. Эндээс манай хөдөлмөрийн хөлсний хэмжээ, системийг шинэчлэн тогтоох шаардлага амьдралаас урган гарч байна.

3. Нийгмийн хөгжил, шаардлагын дагуу засгийн газраас авч байгаа эдийн засгийн арга хэмжээнүүд нь (өмч хувьчлал, үнэ чөлөөлөлт, тэтгэвэр - тэтгэмжийн тогтолцоо, г.м) цаг алдаж хэрэгжиж байгаагаас ядуурал хурдан өсч байна.

а. Тэтгэврийн хуулийн доголдлоос болж тэтгэвэрт суугаа хөдөлмөрийн насны хөдлмөрлөх боломжтой олон хүн тэжээлгэгч болоод байна. Тэтгэвэрт байгаа эрэгтэйчүүдийн 40, эмэгтэйчүүдийн 70 гаруй хувь нь 55-аас доош насных байна. 36-45 насны хүн амын 13 хувь, 46-55 насны хүн амын 20 хувь нь тэтгэвэрт байна. Гэтэл энэ насны тэтгэврийнхний амьдрал тухайн насны хөдөлмөр эрхэлж байгаа

хүмүүсийнхээс доогуур амьдарч байна. Хөдөлмөрийн насны тэтгэвэрт байгаа хотын эмэгтэйчүүдийн 56 хувь, хөдөөгийн 45 хувь нь ядуу байна. Тэтгэвэрт байгаа хөдөлмөрийн насны эмэгтэй тэргүүлэгчтэй хотын өрхийн 76, хөдөөгийн өрхийн 56 хувь нь ядуу амьдарч байна.

6. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлж импортыг бууруулах, гадны нөлөөллөөс хамаарах хамаарлыг багасгах, шинжлэх ухаан, технологийн хөгжлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, г.м.

4. Дэд бүтцийн хөгжил дорой: хот, орон нутагт дэд бүтцийг хөгжүүлэх, боловсронгуй болгох нь зүй ёсоор шаардагдаж байна. Хот, орон нутгийн хөгжлийг даган хүн амын суурьшил, өрх, хүн амын ахуйд тодорхой нөлөөлж, улмаар хүн амын өсөлт, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд нааштайгаар шийдэгдэнэ.